




ТЭНГЭРЛИГ
МЕДИА ГРУПП

ТЭНГЭРЛИГ МЕДИА ГРУПП ЖИЛИЙН ТАЙЛАН 2022





АГУУЛГА

МЭНДЧИЛГЭЭ

КОМПАНИЙН БҮТЭЦ

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ хороод, тогтоол, ирц

НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА

ОХИН КОМПАНИ:
ПРО МЕДИА НЕТВОРК ХХК ҮА ТАЙЛАН
АНРИД: ПРО МЕДИА НЕТВОРК ХХК ҮА ТАЙЛАН

ХАРААТ КОМПАНИ:
МОНГОЛ ДИФАЙ ХХК ҮА ТАЙЛАН
МОНГОЛ ТЕЛЕВИЗ ХХК ҮА ТАЙЛАН
МПЕРС ХХК ҮА ТАЙЛАН
ОРИ СТУДИОС ХХК ҮА ТАЙЛАН

КОМПАНИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН 2022

МОНГОЛЫН АНХНЫ ОЛОН НИЙТИЙН НЭЭЛТТЭЙ
ХУВЬЦААТ МЕДИА ХОЛДИНГ КОМПАНИ

МЭНДЧИЛГЭЭ

Эрхэм хүндэт хувьцаа эзэмшигчид, харилцагчид, бизнесийн түншүүд, хамтран ажиллагсад та бүхнийхээ энэ өдрийн амар мэндийг эрье.

Улиран одогч 2022 он ТэнГэрЛиг Медиа Групп ХК-ийн хувьд салбартаа шинийг бүтээсэн, үзэгч, уншигчиддаа үнэ цэнийг бүтээсэн, амжилт бүтээлээр дүүрэн он байлаа.

ТэнГэрЛиг Медиа Групп (MSE: TNGR) нь Монголын хэвлэл мэдээллийн салбарын анхны олон нийтийн буюу нээлттэй хувьцаат компани бөгөөд өргөн зурвасын телевиз, дижитал медиа, сурталчилгаа, эвент зохион байгуулалт, OTT стриминг болон бүтээлч контент үйлдвэрлэл зэрэг чиглэлүүдээр үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд нээлттэй, хувьцаат медиа компани байснаараа олон нийт хэвлэл мэдээллийн компанийг эзэмших, үйл ажиллагаанд нь хяналт тавих, ашиг өгөөжөөс нь хүртэх боломжийг бүрдүүлж мөн цаашлаад хэвлэл мэдээллийн салбарт шинэ жишиг тогтоож, түүгээрээ дамжуулан нийгэмд эерэг өөрчлөлтийг авчрах зорилготой юм.

Бид цар тахлын хүнд нөхцөлд үйл ажиллагаагаа эхлүүлж байсан хэдий ч маш амжилттай бөгөөд хурдтайгаар ажиллан өнгө төрхөө тодорхойлж, бүтэн брэндинг хийн, www.tngr.media албан ёсны вэбсайтаа хийсний сацуу хаалттай хүрээнд 5,941,457 ширхэг хувьцаа нэмж гаргах зөвшөөрлөө Санхүүгийн

зохицуулах хорооноос 2021 оны 09 дүгээр сарын 8-ны өдрийн №344 тоот тогтоолоор авч, нийт хувьцааны 6,000,000 ширхэг байхаар үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулж байсныг онцлууштай.

Түүнээс хойш тогтвортой үйл ажиллагаагаа өргөжүүлсээр, өдгөө бүрэлдэхүүндээ Про медиа нетворк ХХК (TenGer TV), Анрид ХХК (Unread media), Монгол телевиз (Mongol HD), Ори студиос ХХК, Мперс ХХК гэсэн охин болох хараат компаниудыг багтаан ажиллаж байна. Өнгөрсөн жилийн туршид Монголын Хөрөнгийн Бирж дээрх цорын ганц хэвлэл мэдээлэл, медиа чиглэлийн компани болох манай компанийн (MSE:TNGR) нийт 612 сая төгрөгийн 39 мянган ширхэг хувьцаа арилжаалагджээ.

2022 онд Монгол телевизийн хувьд оюуны өмчийн эрхтэй дотоод гадаадын контент, шоу нэвтрүүлгүүдээрээ салбараа түүчээлж, олон улсын стандартад нийцсэн техник, тоног төхөөрөмжийн тусламжтайгаар мэргэшсэн багтай хамтран дотоод, гадаадын кино, контентуудыг үндсэн форматын дагуу бүтээх зорилготой Ори Студиос төсөл амжилттай эхэлж, барилгын ажил эрчимтэй явагдаж байна.

Оригинал, эерэг контентоор дамжуулан дараагийн үеийнхнийг сэтгэлгээний хувьсгалд уриалан дуудах зорилготой Анрид ХХК нь өөрсдийн оригинал контентуудын цар хүрээг улам тэлж салбартаа жишиг



тогтоосон 500-аас дээш оролцогчтой олон эвент, арга хэмжээнүүдийгулирал бүр амжилттай зохион байгууллаа. Ажил хэрэгч, мэдээ мэдээлийн телевиз хэмээх тодотголтой TenGer TV албан ёсны эфирээ тавдугаар сард эхлүүлж, тэнцвэртэй, хараат бус, олон талт агуулга бүхий мэдээллийн хөтөлбөрүүдээ хүргэж, үзэгчдийн итгэл, талархлыг хүлээсэн үнэ цэнийг бүтээж байна. Амжилтаа ахиулсаар ирсэн түүхэн он цагийн хэлхээнд бидэнтэй хамт байсан нийт хувьцаа эзэмшигчид, хөрөнгө оруулагчид, бизнесийн түншүүд, хамтран ажиллагсад та



бүхэндээ сайн сайхан бүхнийг хүсэн ерөөж, 2023 он бидний хувьд дараагийн үсрэнгүй амжилтын жил байх болно гэдэгт итгэл дүүрэн байна.

Хүндэтгэсэн,
ТУЗ-ийн дарга
Г. Уянга

Гүйцэтгэх захирал
Г. Бат-Эрдэнэ

ТэнГэрЛиг Медиа Групп (MSE: TNGR) нь Монголын хэвлэл мэдээллийн салбарын анхны олон нийтийн буюу нээлттэй хувьцаат компани бөгөөд өргөн зурвасын телевиз, дижитал медиа, сурталчилгаа, эвент зохион байгуулалт, OTT стриминг болон бүтээлч контент үйлдвэрлэл зэрэг чиглэлүүдээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Группын бүрэлдэхүүнд одоогийн байдлаар:

Хараат компани: Монгол ТВ, ОриСтудиос, Мперс, Монгол Дифай компаниуд хамаарагдаж буй.

Охин компани: ТэнГэр ТВ, Анрид

Яагаад?

- Нээлттэй, хувьцаат медиа компани байснаараа олон нийт хэвлэл мэдээллийн компанийг эзэмших, үйл ажиллагаанд нь хяналт тавих, ашиг өгөөжөөс нь хүртэх боломжийг бүрдүүлж байгаа. Мөн цаашлаад хэвлэл мэдээллийн салбарт шинэ жишиг тогтоож, түүгээрээ дамжуулан нийгэмд эерэг өөрчлөлтийг авчрах зорилготой юм.

Зорилго

- Монголын медиа салбарын анхны олон нийтийн нээлттэй хувьцаат, ил тод, хараат бус байдлыг хангасан, нэгдмэл редакцын бодлоготой групп компани болох
- Медиа салбарт шинэ жишиг тогтоож, зах зээлийг томсгон, үр нөлөөг ихэсгэж, түүгээрээ дамжуулан нийгмийг эерэг өөрчлөлтөд хөтлөх
- Уламжлалт болон дижитал медиа, OTT, технологийн инновациудыг нэгтгэж, хүн бүрт контентийн боломжит бүх төрлөөр, төхөөрөмжид үл хязгаарлагдан хүрэх


Алсын хараа

Эзэмших ирээдүй. Бүтээх ухамсар.
(Өөрөө эзэмших ирээдүй. Ирээдүйгээ эзэмш.)

Үнэт зүйлс

- Хараат бус / Independent
- Ил тод, нээлттэй / Transparent
- Бүтээлч / Creative
- Инновацилаг / Innovative
- Хүртээмжтэй / Accessible

КОМПАНИЙН БҮТЭЦ



ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД, %



2021/12/31	
Нэгжийн хаалтын ханш	20,000₮
Нийт хувьцаа	6,000,000
Нийт үнэлгээ	120 т6



2022/12/31	
Нэгжийн хаалтын ханш	16,900₮
Нийт хувьцаа	6,000,000
Нийт үнэлгээ	101 т6

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

ЕРДИЙН ГИШҮҮД



Г.Уянга

Боловсролын байдал

- 2002 Санхүү Эдийн Засгийн Дээд Сургууль, Банк санхүү
- Хартфорт дээд сургууль, MBA

Ажилласан байдал

- 2019 Ард Пропертиз ХХК, Гүйцэтгэх захирал
- 2009 Арван гэрийн холбоо ХХК, Гүйцэтгэх захирал
- 2005 Грасрүүтс жижиг дунд бизнес дэмжих төв (НҮБ-ийн төсөл), Захирал




Г.Бат-Эрдэнэ

Боловсролын байдал

- 2006 Улс төр нийгэм судлал, Зүүн Англи Норвичийн Их Сургууль
- 2016 Удирдах албан тушаалтны хөтөлбөр, Харвард Бизнесийн сургууль

Ажилласан байдал

- Монгол Телевиз ХХК, Гүйцэтгэх захирал
- Монголын телевизүүдийн холбоо, УЗ-ийн дарга
- Монгол Телевиз ХХК, Стратеги бодлого төлөвлөлт хариуцсан дэд захирал
- Номсис ХХК, Ерөнхий захирал



Н.Мөнхнасан

Боловсролын байдал

- 2003 Санхүү эдийн засгийн удирдлага, Сан Францискогийн их сургууль
- 2008 Санхүүгийн инженер Магистр, Жорж Вашингтон их сургууль

Ажилласан байдал

- Монполимет Групп, ТУЗ-ийн дарга
- Дэлхийн банк төв оффис АНУ, Монгол улсыг хариуцсан эдийн засагч
- Монголбанк, Эдийн засагч
- ANN ХХК, Үүсгэн байгуулагч, Ерөнхий захирал

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

ЕРДИЙН ГИШҮҮД



Ч.Батхүү

Боловсролын байдал

- 2011, Олон улсын харилцаа, Loughborough University
- #### Ажилласан байдал
- Брикланд ХХК, Ерөнхий захирал



А.Ундрал

Боловсролын байдал

- 2008 Эдийн засаг МУИС
- 2018 Менежмент магистр, Львений Их сургууль

Ажилласан байдал

- ТэнГэр Телевиз, Гүйцэтгэх захирал
- Анрид ХХК, Гүйцэтгэх захирал
- Монголын үндэсний олимпын хороо, Нарийн бичгийн даргын орлогч
- UBS Телевиз, сэтгүүлч, редактор



Б.Золбоо

Боловсролын байдал

- 2013 Олон улсын нягтлан бодох бүртгэл, СЭЗИС
- 2016, Эдийн засагч, Plattsburgh коллеж

Ажилласан байдал

- Ард Санхүүгийн Нэгдэл, Санхүү эрхэлсэн захирал
- Ард Менежмент, Гүйцэтгэх захирал
- Ард Менежмент, Хөрөнгө оруулалтын шинжээч
- Ард Секьюритиз ҮЦК, Хөрөнгө оруулалтын шинжээч

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

ХАРААТ БУС ГИШҮҮД



В.Ганзориг

Боловсролын байдал

- 2001 Бизнесийн удирдлага, ХҮДС
- 2005 Бизнесийн удирдлага мастер, Австрали Нотр Дэймийн их сургууль
- 2010, Цахим бизнесийн удирдлага мастер, Японы олон улсын их сургууль

Ажилласан байдал

- BSP, УЗ-ийн дарга
- Медиа Групп, Гүйцэтгэх захирал
- Шунхлай Групп, Стратеги хариуцсан захирал



Н.Цогт

Боловсролын байдал

- 1994 Москва АХДС
- 2005 Хамлын их сургууль

Ажилласан байдал

- Бона лекс хуулийн товчоо, Хуульч захирал
- Хууль Зүйн Дотоод Хэргийн Яам, Ахлах мэргэжилтэн
- Үндэсний хөгжлийн газар, Мэргэжилтэн



Б.Наранзун

Боловсролын байдал

- 1997 Монгол Улсын Их Сургууль

Ажилласан байдал

- Лето Мьюзик ХХК, Гүйцэтгэх захирал
- АПУ ХК, ОНХХ хариуцсан захирал
- АПУ ХК, ХН хариуцсан захирал
- Шунхлай Групп, ОНХХ хариуцсан захирал


ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ хороод

АУДИТЫН ХОРОО



В.Ганзориг Ч.Батхүү Б.Наранзун

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, САНХҮҮ ЭРСДЭЛИЙН ХОРОО



Б.Золбоо Н.Мөнхнасан А.Ундрал В.Ганзориг

ЗАСАГЛАЛ, НЭР ДЭВШҮҮЛЭХ, ЦАЛИН УРАМШУУЛЛЫН ХОРОО



Г. Уянга Н.Цогт Б.Наранзун

УДИРДЛАГЫН БАГ




Г.Бат-Эрдэнэ Д. Бат-Оюун

Гүйцэтгэх захирал

Санхүү эрхэлсэн захирал

ОХИН КОМПАНИЙН УДИРДЛАГА



А. Ундрал Д. Ганзориг

Тэнгэр ТВ гүйцэтгэх захирал

Unread гүйцэтгэх захирал

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ ТОГТООЛ

13

ЭЭЛЖИТ БОЛОН
ЭЭЛЖИТ БУС
ХУРАЛ

6

ХОРООДЫН
ХУРАЛ

9

ЭЧНЭЭ САНАЛ
ХУРААЛТ

13

ШИЙДВЭРЛЭСЭН
АСУУДЛЫН ТОО

Нэрс	Нийт хурлын тоо	Хуралд хамрагдсан байдал	Хувьцааны тоо
Г.Уянга	4	Биечлэн 3, цахим 1	1,940
Г.Бат-Эрдэнэ	4	Биечлэн 3, цахим 1	692,292
А.Ундрал	4	Биечлэн 3, цахим 1	-
Н.Мөнхнасан	3	Төлөөлөгч 3	600,000
В.Ганзориг	3	Биечлэн 1, цахим 2, оролцоогүй 1	-
Б.Золбоо	3	Биечлэн 2, цахим 1, оролцоогүй 1	185
Ч.Батхүү	3	Цахим 3	-
Н.Цогт	2	Цахим 2, оролцоогүй 2	-
Б.Наранзун	3	Биечлэн 3, цахим 1	-

НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА

ТЭРБУМ МОД ТӨСӨЛ

ЦЕГ-с хэрэгжүүлсэн “Тэрбум мод” төслийг дэмжин контентийн үнээ хямдруулан нийтлэл гаргасан

АРТСКЭЙП

АРТСКЭЙП үзэсгэлэнгийн ашгийн тодорхой хувийг алслагдмал хөдөө орон нутгийн хүүхдүүдэд зориулж эмнэлгийн тоног төхөөрөмж, түргэний машин авахад зориулсан

DISABILITY EXPO-2022

“Хүртээмжтэй хөгжлийн дэвшилттэй шийдлүүд: хүртээмжтэй эрх тэгш байдлыг дэмжихэд инновацын үүрэг” уриан дор зохион байгуулагдсан Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нэгдсэн “DISABILITY EXPO-2022” арга хэмжээнд медиа хамтрагчаар ажиллав

МЕДИА ХАМТРАГЧ БАЙГУУЛЛАГА

Монголын спортын холбоо, Teach for Mongolia, Харилцаа холбоо зохицуулах хороонд зар сурталчилгааны үйлчилгээ үзүүлсэн. “Монголын Урлагийн зөвлөл”-өөс 14 дэх удаагийн “Улаанбаатар” Олон Улсын Кино Наадамд сурвалжлага бэлтгэн мөн нэвтрүүлэгт зочноор оруулсан

РОТАРИ ӨДӨР

Нийгмийн сайн сайхны төлөө Ротаричуудын хийж бүтээсэн, мөн хэрэгжүүлж буй, төлөвлөж буй төслүүдийг олон нийтэд түгээхээр хэвлэл мэдээллийн дэмжигчээр ажиллав

БЯЦХАН БААТРУУД ТӨСӨЛ

Монголын Ротаракт клубуудын 2012 оноос хойш 10 дахь жилдээ амжилттай хэрэгжүүлж буй “Бяцхан баатрууд” төсөлд мөнгөн хандив өгсөн

UB CAB CARE ТӨСЛИЙН ХАМТРАГЧ БАЙГУУЛЛАГА

Хөгжлийн бэрхшээлтэй иргэд тээврийн хэрэгслээр саадгүй зорчих боломжийг олгох зорилготой, тулгуур эрхтний бэрхшээлтэй буюу тэргэнцэртэй зорчигчдод зориулсан, тусгай сургалтад хамрагдсан мэргэжлийн жолооч үйлчилж, тээврийн хэрэгсэлд суух буух болон бусад шаардлагатай үед дэмжлэг үзүүлэх UB CAB CARE төслийн хүрээнд нэг иргэний бүтэн жилийн унаа, үйлчилгээний зардлыг төлж хамтран ажиллахаар болов

БОЛОМЖИЙГ БҮГДЭД

Тусгай хэрэгцээт хүүхдүүдийн эрхийг хамгаалах, нийгмийн хандлагыг чиглүүлэх, ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрөх, спортоор дамжуулан тэднийг хөгжүүлэхэд эцэг эх болон олон нийтийг уриалах, оюуны бэрхшээлийн талаар мэдлэг олгох, Тусгай Олимпыг бүс нутгуудад таниулах, зорилготой “Боломжийг бүгдэд” төслийн сурвалжлах багаар ажиллав

ЭНТРЕПРЕНЕР СУДЛААЧ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР

Шинжлэх ухааны Академийн дунд хугацааны стратеги төлөвлөгөөний хүрээнд хэрэгжүүлэх “Энтрепренер Судлаач” үндэсний хөтөлбөрийг дэмжин хэвлэл мэдээллийн хамтрагчаар ажиллаж байна

ПРО МЕДИА НЕТВОРК ХХК



Үйл ажиллагааны чиглэл

Бизнес мэдээ, контент үйлдвэрлэл, шууд эфир

Товч танилцуулга

Бид өөрсдийн шинэлэг, өвөрмөц форматтай нэвтрүүлгүүдээр дамжуулан ялгаатай үзэл бодол, олон талын дуу хоолойг нэгтгэж, хоорондоо ярилцан ойлголцох, мэдээллээ хуваалцах, мэдлэг туршлагаа солилцох боломжийг бүрдүүлсэн нээлттэй амьд харилцааг эрхэмлэн ажилладаг бөгөөд Бизнесийн шударга өрсөлдөөнийг дэмжиж, уур амьсгалын өөрчлөлтөд анхаарал хандуулан, нийгмийн тэгш байдлын төлөөх дуу хоолой болохын сацуу Монголын санхүүгийн зах зээлийн хөгжлийн төлөө зүтгэж, үзэгчдийн соён гэгээрүүлэх эрхэм зорилготой

Хүний тоо

75+

Алсын хараа

- Бизнес мэдээллийн гол эх сурвалж байна.
- Телевиз суурьтай медиа брэнд бий болгоно.
- Цаг үеийг мэдэрч, технологиор тэргүүлнэ.
- Нийгмийн тэгш байдлын дуу хоолой болно.

Контент стратеги

- Гүн рүү шумбана
- Үнэт зүйлсээ эрхэмлэнэ
- Анхаарлыг татна
- Амьд байна
- Олон талт үзэл бодлыг хүндэтгэнэ



2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

АЖИЛ ХЭРЭГЧ МЭДЭЭ МЭДЭЭЛЛИЙН СУВАГ

КОНТЕНТУУД

TenGer TV нь 2022 оны 5-р сарын 30-нд албан ёсоор эфирээ эхлүүлж, одоогийн байдлаар долоо хоног тутам 30 орчим оригинал контентыг бүтээн, үзэгчдийн хүртээл болгож байна.

Мэдээ

- 7:10 мэдээллийн хөтөлбөр
- 1:10 мэдээллийн хөтөлбөр
- Гадаад мэдээ
- TechGer: Технологийн мэдээ
- Спортономикс: Спортын мэдээ
- Билиг: Шинжлэх ухааны мэдээ
- Крипто цаг: Крипто мэдээ
- Энтертэймент мэдээ
- Цэг хооронд: Тээврийн мэдээ
- Гэр хөрөнгө: Үл хөдлөхийн мэдээ
- Хөтөч мэдээ

Оригинал

- Гэж юу вэ?
- Дур булаам шинжлэх ухаан
- Тархи
- Нүүдэлчдийн түүх
- Хадгалах нь
- Онцлох бизнес
- Улаанбаатарын таатай оффис
- 10 баримт
- Хуйвалдааны хүрд
- Хувьсгалын хүрд
- Эвент тойм

Ярилцлага

- Анхаар
- Энэ тухай
- Өнөөдрийн сэдэв
- Зүй тогтол
- Тусгай хэлэлцүүлэг
- Буухиа
- Де Факто тойм
- Де Факто ярилцлага

13:10 ӨДРИЙН МЭДЭЭЛЛИЙН ХӨТӨЛБӨР

TenGer TV-ийн мэдээллийн хөтөлбөр нь дотоод, гадаад орчинд өрнөж буй хамгийн анхаарал татсан чухал сэдвүүдийг мэргэжлийн байдлаар хөндөж, олон талт эх сурвалжуудын дуу хоолойг баримт, тоон өгөгдөл дээр тулгуурлан хүргэдэг.


Үргэлжлэх хугацаа: 30 минут
Давтал: 1-2 удаа
Шууд эсэх: Тийм



РЕДАКЦЫН АСУУДАЛ ХӨНДСӨН КОНТЕНТ



Тусгай хэлэлцүүлэг
Редакцийн сонгосон сэдвийн хүрээнд оролцогч талуудын төлөөллийг хамруулсан өргөн хүрээний бүтээлч хэлэлцүүлэг
Хугацаа: 180 мин
Давтамж: Сар бүр
Давтал: 4 удаа



Буухиа
Нийгмийн үзэл санаа, үнэт зүйл, чиг хандлагын талаар өөр өнцөг, ялгаатай байр суурь бүхий эрхэмүүдийг оролцуулсан ярилцлага
Хугацаа: 300 мин
Давтамж: Жил бүр
Давтал: Тогтмол

ҮНДЭСНИЙ ТҮҮХ, СОЁЛ, УЛАМЖЛАЛЫН КОНТЕНТ



Тусгай хэлэлцүүлэг
Редакцийн сонгосон сэдвийн хүрээнд оролцогч талуудын төлөөллийг хамруулсан өргөн хүрээний бүтээлч хэлэлцүүлэг
Хугацаа: 180 мин
Давтамж: Сар бүр
Давтал: 4 удаа



Хадгалах нь
Үндэсний өв соёл, уламжлалын хамгийн чухал элементүүдийг хэрхэн хадгалж, хамгаалдаг тухай өгүүлэх цуврал
Хугацаа: 10-15 мин
Давтамж: 14 хоног бүр
Давтал: 20 удаа

ТАНИН МЭДЭХҮЙН ЦУВРАЛУУД




Хуйвалдааны хүрд
Түүхийн хамгийн сонирхолтой эгшин, үйл явдлуудаар дамжуулан нийгмийн сэтгэл зүйг тайлбарлах түүхэн цуврал
Хугацаа: 20 мин
Давтамж: 7 хоног бүр
Давталт: 10 удаа




Хувьсгалын хүрд
Нийгмийн хувьсгал, өөрчлөлтийн үйл явц түүхэн цаг хугацаанд өөр өөр орчинд хэрхэн өрнөснийг өгүүлэх цуврал
Хугацаа: 20 мин
Давтамж: 7 хоног бүр
Давталт: 10 удаа

ҮНДЭСНИЙ ТҮҮХ, СОЁЛ, УЛАМЖЛАЛЫН КОНТЕНТ



Дур булаам шинжлэх ухаан
Нийгмийн асуудал, өдөр тутмын сорилтуудыг шинжлэх ухаанчаар тайлбарлах ток шоу
Хугацаа: 50 мин
Давтамж: 7 хоног бүр
Давталт: 4 удаа







Билиг
Шинжлэх ухаан, академик ертөнцөд өрнөж буй хамгийн сүүлийн үйл явдлыг эрдэмтдийн үгээр тайлбарлан хүргэдэг долоо хоног тутмын мэдээ
Хугацаа: 30 мин
Давтамж: 7 хоног бүр
Давталт: 3 удаа

ХҮҮХДЭД ЗОРИУЛСАН НЭВТРҮҮЛЭГ



Тархи
Тархи хэрхэн ажилладаг тухай өсвөр насныханд зориулсан цуврал. Оюун, сэтгэл санааны хөгжлийн хүний үүсэл хөгжил, нийгмийн нөхцөл байдалтай уялдуулан сонирхолтой дүрслэл, зураглалаар илэрхийлнэ.

Үргэлжлэх хугацаа: 20 мин
Давтамж: 14 хоног бүр
Давталт: 20 удаа



Илгээ
Энхийг сахиулагчид болон гэр бүлээсээ зайнаас ажиллаж буй эцэг эхдээ мэндчилгээ илгээж, сэтгэлийн үгсээ хуваалцаж буй контент
Үргэлжлэх хугацаа: 20 минут
Давтамж: Улиралд
Давталт: 5 удаа

10 баримт
Сонирхолтой, мэдүүштэй зүйлсийг 10 баримтад багтаан хүргэх хүүхдэд зориулсан богино хэмжээний цуврал
Үргэлжлэх хугацаа: 5-10 минут
Давтамж: 7 хоног бүр
Давталт: Өдөр бүр

ТОЙМ БОЛОН ЯРИЛЦЛАГЫН КОНТЕНТУУД



Jargal De Facto
 Нийгмийн гол дүр, төлөөлөгчидтэй чухал санаа, шийдлийн талаар ярилцах нүүр тулсан ярилцлага
 Хугацаа: 30 мин
 Давтамж: 7 хоног бүр
 Давталт: 2 удаа



De Facto тойм
 Монголын нийгэмд өрнөсөн хамгийн онцлох үйл явдлыг онцлон тайлбар өгөх экспертүүдийн өнцөг бүхий тойм хөтөлбөр
 Хугацаа: 30 мин
 Давтамж: 7 хоног бүр
 Давталт: 2 удаа

БИЗНЕС, БҮТЭЭМЖИЙН КОНТЕНТ




Онцлох бизнес
 Нийгмийн асуудал, өдөр тутмын сорилтуудыг шинжлэх ухаанчаар тайлбарлах ток шоу
 Хугацаа: 50 мин
 Давтамж: 7 хоног бүр
 Давталт: 4 удаа



Улаанбаатарын таатай оффис
 Ажлын байрны чиг хандлагатай хөл нийлүүлж буй хамгийн шилдэг компаниудын оффисыг алдаршуулна
 Хугацаа: 15
 Давтамж: Жил бүр
 Давталт: Тогтмол

ХАМТАРСАН КОНТЕНТ



Бизнес өрөг
 Бизнесийн салбарын хамгийн онцлох эрхэмүүдийг танилцуулна
 Хугацаа: 70 минут
 Давтамж: 7 хоног бүр
 Давталт: 2 удаа



Синдикат ток
 Нийгмийн хамгийн тулгамдсан асуудлын хүрээнд хэлэлцүүлэг өрнүүлнэ
 Хугацаа: 60 минут
 Давтамж: 2 долоо хоног бүр
 Давталт: Тогтмол

ЭВЕНТ, ШУУД ДАМЖУУЛАЛТУУД

ЭВЕНТ ТОЙМ НЭВТРҮҮЛГҮҮД



MEMENTO 2022



DEVSUMMIT 2022



UNPLUG



DIGITAL BRIDGE 2022




НҮҮДЭЛЧДИЙН ФЕСТИВАЛЬ



МАШ ОНДОО

ШУУД БОЛОН ШУУРХАЙ ДАМЖУУЛАЛТУУД



January

15 холбоодын нэгдсэн улсын аварга шалгаруулах тэмцээний шууд дамжуулалтын багт ажиллав.

February

Бээжин 2022 өвлийн олимпын наадмыг шууд дамжуулж, 2 хүнтэй багийг илгээлээ.

April

Монголын Эдийн Засгийн чуулганы албан ёсны түншээр ажиллалаа.

July


Баяр наадмын шууд дамжуулалтын багт ажиллав.

ШУУД БОЛОН ШУУРХАЙ ДАМЖУУЛАЛТУУД



September

Уул уурхайн 7 хоног-2022 арга хэмжээний шууд дамжуулалтын түншээр ажиллалаа.



September

Дорнын эдийн засгийн чуулганыг шууд дамжуулав.



September

Их Британийн хатан хааны оршуулгыг шууд дамжуулав.



October

Нобелийн шагналтан зарлах ёслолыг долоо хоногийн турш Монгол тайлбартайгаар дамжууллаа.

ОЛОН УЛСЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА

TenGer TV-ийн сэтгүүлч, продюсерүүд мэргэжлийн ур чадвараа нэмэгдүүлэх зорилгоор олон улсын тэтгэлэгт хөтөлбөр, сургалтад шалгарч оролцов.

2022 онд Thomson Reuters Foundation, Asia Europe Foundation, National Press Foundation, News Product Alliance, Youtube News Creator, Kontinentalist зэрэг байгууллагуудтай хамтран ажиллав.



TenGer TV нь мэдээний редакцийн үр ашигт байдлыг нэмэгдүүлж, хамтын ажиллагааг өргөжүүлэх, контентын чанарыг өсгөх зорилгоор олон улсын төсөл, хамтын ажиллагаанд тогтмол хамрагдахыг эрмэлздэг.

Энэ жилийн хувьд Олон Улсын Сэтгүүлчдийн Төвийн “Мэдээний Инновацын Лаборатор”, “Covering Climate Now”, “Meedan” зэрэг хөтөлбөрүүдэд шалгарч, төсөл хэрэгжүүлэх тэтгэлгийн эзэн болжээ.



АНРИД ХХК



Үйл ажиллагааны чиглэл

Медиа, контент үйлдвэрлэл, эвент зохион байгуулах

Товч танилцуулга

Unread Media бол оригинал, эерэг контентоор дамжуулан дараагийн үеийнхнийг сэтгэлгээний хувьсгалд уриалан дуудах зорилготой хосолмол медиа стартап юм. Контент гэдэгт бид өгүүлэмж (storytelling), арга хэмжээ (events), коммюнити (community)-г багтаадаг бөгөөд оновчтой агуулга, урамтай хэлбэрээр хэрэглэгчдийг гүнзгий суралцахад, далайцтай сэтгэхэд, илүүг бүтээхэд замчлах нь бидний чин эрмэлзэл.

Хүний тоо

15+

Үйлдэлд хөтлөх санаанууд. Урам өгөх түүхүүд. Гэрэл тусгах цэгүүд. Гэгээ цацраах дүрүүд. Нарийвчлан харуулах өнцөг. Бүрэн зураглах ойлголт. Таниулах ёстой туршлага. Хүргэх учиртай мэдээлэл. Дэвшилтэт сэтгэлгээний охь. Бадрангуй бодлын оч.

Энэ бүхнийг бид хэрэглэгчдийн сонор, мэлмийд сорчлон хүргэхийг зорьдог. Ингэхдээ контентын бүх л төрөл хэлбэрийг сонгон хамгийн ойлгомжтой, шингээхэд хялбар аргыг ашигладаг билээ.

Алсын хараа

Залуу мэргэжилтнүүд руу чиглэсэн Монголын тэргүүлэгч медиа байх

Бидний бий болгосон үнэ цэн

Өнгөрсөн 7 жилийн хугацаанд бид шинэ үеийн залуу мэргэжилтнүүдэд зориулан хувь хүний хөгжил, технологи, гарааны бизнесийн орчинд өрнөж буй бүхий л мэдээ мэдээллийг хүргэхээр зорьсоор ирсэн нь Монголын гарааны бизнесийн орчинг төлөвшүүлэн хөгжүүлэхэд багагүй хувь нэмэр болжээ.

Үлгэр жишээ дүрүүд, ажлын арга барилаа төлөвшүүлэх, сурч хөгжих чиглэлээ хайж буй залуу мэргэжилтнүүдэд Unread хэзээд найз нь, хөтөч нь байсаар, болсоор ирсэн нь бидний ажлын гол үнэ цэн юм.




UNREAD™

2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

БҮТЭЭГЧ ХҮМҮҮСТ ЗОРИУЛАВ


ОНЫ ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

- Dev Summit 2022 арга хэмжээг амжилттай зохион байгуулав.
- Үндэсний их баяр наадмын брэндийн медиа ажлын хэсгийг хариуцан ажиллав.
- Playtime 2022 арга хэмжээтэй хамтран ажиллав.
- Momento-2022 арга хэмжээг зохион байгуулав.
- “Unplug 2022” үйл ажиллагааг амжилттай зохион байгуулав.
- SGM - “Нээлттэй төсөв” өгөгдлийн тэмцээнийг зохион байгуулав.
- Рио Тинто Монгол компанийн ажилчдын нэгдсэн “ЯРИО” уулзалт арга хэмжээг зохион байгуулав.
- Капитрон банкны ажилдын нэгдсэн уулзалтыг зохион байгуулж, брэндингийн ажлыг хийж гүйцэтгэв.



НИЙТЛЭЛ

2022 онд нийт 20 буланд 650 орчим нийтлэл оруулсан байна. Мөн “Таатай хотхон” контентыг шинээр эхлүүлэн Sky Garden, Bella Vista хотхонуудтай хамтран ажилласан байна.



Булан

- Онцлох /Даваа/
- Techworm /Мягмар/
- Би хэрхэн ажилладаг вэ? /Лхагва/
- Мэдүүштэй /Пүрэв/
- Чөлөөт /Баасан/
- Номын тухай /Бямба/
- 7 хоногийн тойм /Ням/



Шинэ

- Өртөөлөгчид
- Аравт
- Тогтвортой хөгжил
- Тайлбарлах нь
- А-Я
- 10 ертөнц, 10 өнцөг
- Би хүүхдээ ингэж өсгөдөг
- Танилц, миний амьтан
- Таатай оффис
- Зочин нийтлэлчийн булан
- 8 минутын улс төр
- Study Hacks

ВИДЕО

Видео контентуудыг тогтмолжуулж, нийтлэлд зориулсан богино бичлэгүүдийг идэвхтэй хийж эхэлсэн. Үүнд:

- 7 хоног тутмын “7 хоногийн тойм”
- Баасан гараг бүрийн “Weekly Booster”
- Салбар бүрдээ амжилт бүтээлээрээ танигдсан эрхмүүдийг танилцуулах “Elements” зэрэг контентууд орно.



Unread Gift Guide 2022 | Итгэлт эрчүүдээ зориулах бэлгийн хөтөч
Unread 6.71K subscribers




'Elements' #1 - Төрийн соёрхолт, дуучин, продюсер Д.Болд
Unread 10.0K subscribers

ЭВЕНТ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

“Dev Summit 2022”

- 500-800 оролцогч
- 20+ хамтрагч тал
- 15 илтгэгч
- Жил бүрийн 3-5 сард



“Unplug 2022”

- 700+ оролцогч
- 30+ хамтрагч тал
- 20+ илтгэгч
- 10+ сэдэв
- 40+ сайн дурын ажилтан



SGM “Нээлттэй төсөв” өгөгдлийн тэмцээн

- Европын Холбоо, Дэлхийн банкны дэмжлэгтэйгээр Монгол Улсын Сангийн яам Unread Media компанитай хамтран “Нээлттэй төсөв” өгөгдлийн тэмцээнийг арванхоёрдугаар сарын 9-нд зохион байгуулсан билээ.
- 35 гаруй оролцогчид
-



ЭВЕНТ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ


Рио Тинто Монгол Компанийн ажилчдын нэгдсэн уулзалт

- Рио Тинто группийн ажилчдад зориулсан сургалт
- 250+ оролцогч
- Сар бүр зохион байгуулагдана



Капитрон банкны ажилчдын нэгдсэн уулзалт

- 500-800 оролцогч
- 20+ хамтрагч тал
- 15 илтгэгч
- Жил бүрийн 3-5 сард



ТӨСӨЛ ХӨТӨЛБӨР


“SGM”

- Дэлхийн банк (ДБ) болон Европын холбоо (ЕХ) хамтран Монгол Улсын Засгийн газрын төсвийн орлогыг сайжруулахад чиглэсэн хүчин чармайлтыг дэмжих зорилготой Монгол Улсад засаглалыг бэхжүүлэх (SGM) төсөл юм.



“SDG 2030”

- Тогтвортой хөгжлийг цогцлоохын хүрээнд “Тогтвортой хөгжил - 2030” цахим товхимлыг Тогтвортой хөгжлийг дэмжигч ХААН Банктай хамтран бэлтгэж хоёр долоо хоногтоо нэг удаа, пүрэв гарагт хүргэдэг билээ.




SGM “Toyota Safetybook”

- Замын хөдөлгөөний аюулгүй байдлаас үүдэлтэй ослын тоог бууруулахад эерэгээр нөлөөлөх, бага насны хүүхдүүдэд холбогдох мэдлэг мэдээллийг олгох зорилготойгоор “Тоёота Сэйлс Монголиа” компани гуравдахь жилдээ “Toyota Safetybook” төслийг санаачлан хэрэгжүүлж буй билээ.



“НААДАМ 2022” брэндийг таниулах хөтөлбөр

- Naadam.mn сайтын мэдээ мэдээлэл
- Сошиал хуудсууд
- Тасалбар захиалга, болон зогсоол захиалгын мэдээ мэдээлэл
- Наадам брэндигийн өнгө төрхийг наадамчин олонд таниулан хоногшуулах
- Жил жилийн наадмын нэгдсэн мэдээллийг цэгцтэй, сонирхолтой байдлаар хүргэн ажилласан.



ХАМТРАН АЖИЛЛАГЧ БАЙГУУЛЛАГУУД



МОНГОЛ ДИФАЙ ХХК



Үйл ажиллагааны чиглэл

Программ хангамжийн үйл ажиллагаа, бизнесийн зөвлөгөө өгөх

Товч танилцуулга

Монгол Дифай ХХК нь Монгол улсын анхны стэйблкойн (валютын нөөцөөр баталгаажсан үнэ цэнийг энгийн хэрэглээний валюттай аргамжсан криптовалютын төрөл) болох MONT-ыг 2021 оны 10-р сарын 29-ний өдөр зах зээлд гаргаж үйл ажиллагаагаа эхэлсэн. Монгол дифай ХХК нь MONT-ын зах зээлийн нийлүүлэлтийг хянаж, цаашдын хөгжүүлэлт болон интеграц хийх төслүүдийг удирдан чиглүүлэх замаар MONT-ын хэрэглээг олон улсын зах зээлд гаргах зорилготой

Хүний тоо

3

Алсын хараа

Крипто, блокчэйн ертөнцийг уламжлалт санхүүгийн ертөнцтэй холбох.

Эрхэм зорилго

Бид MONT-ын зах зээлийн нийлүүлэлтийг хянаж, цаашдын хөгжүүлэлт болон интеграц хийх төслүүдийг удирдан чиглүүлэх замаар MONT-ын хэрэглээг олон улсын зах зээлд гаргахаар зорин ажиллаж байна.

MONT нь Монгол Төгрөгтэй аргамжсан, Төгрөгийн нөөцөөрөө баталгаажсан стэйблкойн. MONT стэйблкойн нь виртуал хөрөнгө болон бусад валют руу түргэн шуурхай, чөлөөтэй хөрвөж виртуал хөрөнгийн арилжааг хялбарчилна.



2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

MONT (Mongol Tether)-ийн талаар

2.82 тэрбум MONT

зах зээлд эргэлдэж буй хэмжээ

100,000+

MONT эзэмшигчид

170.7 сая ₮

24 цагийн арилжааны хэмжээ

20.7 тэрбум MONT

2022 оны нийт блокчэйн гүйлгээ

2 блокчэйн сүлжээ

Binance Smart Chain, Polygon

7.1 сая ₮

Дундаж блокчэйн гүйлгээний дүн


ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОНЦЛОХ ТАЙЛАН

Лист хийгдсэн биржүүд:



Үйл ажиллагаагаа эхлүүлснээс хойш idax.exchange, Trade.mn, denode.io, Corex.mn биржүүд дээр лист хийж арилжаалагдаж байна.

Зах зээл дээрх MONT-ын хэмжээ:



ХАМТРАН АЖИЛЛАГЧ БАЙГУУЛЛАГУУД

Технологийн хамтрагчид:



Хамтран ажиллаж буй блокчэйн төслүүд:



Хамтран ажиллаж буй финтек байгууллагууд:



ДЭЛХИЙН ШИЛДЭГ КОНТЕНТУУДЫГ
НЭГ ДОР ҮЙЛДВЭРЛЭГЧ МОНГОЛЫН АНХНЫ
АЗИЙН ШИЛДЭГ ТЕЛЕВИЗ



ХАМГИЙН ОЛОН СОШИАЛ
ДАГАГЧ, ХАНДАГЧТАЙ ТЕЛЕВИЗ



ХАМГИЙН ОЛОН ЦАГИЙН ШУУД
ЭФИР НЭВТРҮҮЛДЭГ ТЕЛЕВИЗ



МОНГОЛ ТЕЛЕВИЗ ХХК



Үйл ажиллагааны чиглэл
Медиа салбарыг түүчээлэгч Монгол Телевиз

Товч танилцуулга
“Монгол ТВ” телевиз нь Монголд анх удаа оюуны өмчийн онцгой эрхтэйгээр дотоод гадаадын бүхий л контентуудыг худалдан авч, дуу дүрсний өндөр чанартайгаар үзэгчдэд хүргэхээс гадна дэлхийн томоохон шоу нэвтрүүлгийн форматаар Монголд шоу нэвтрүүлгүүдийг амжилттай бүтээж, Монголын нэвтрүүлгийн стандартад шинэчлэл хийж байна.

Хүний тоо
170+

- Үнэт зүйл
- Шударга үнэн;
 - Чин сэтгэл;
 - Хичээнгүй зүтгэл;
 - Чанд хариуцлага;

Эрхэм зорилго
Чанартай, сонирхолтой бүтээлийг ёс зүйг эрхэмлэн туурвиж, түгээж, олон нийтийг соён гэгээрүүлэх замаар нийгэмд эерэг өөрчлөлт бий болгон, салбартаа түүчээлэн тэргүүлж, үнэт өв үлдээнэ.

Алсын хараа
Уран бүтээлч сэтгэлгээг тэтгэн, бүтээн туурвиж хөгжин чадваржих орчныг бүрдүүлэгч удирдлагатай, мэргэжлийн уран чадвар, чанд хариуцлага бүхий оргилсон эрч хүчтэй, сэтгэл хангалуун бүтээлч хамт олонтой, мэдлэг боловсрол, гоо зүй, ёс зүйг дээдлэн шилдэг технологиор туурвисан бүтээлтэй, ашигтай, итгэлтэй бодит үнэ цэнийг хүртэгч харилцагчтай, тогтвортой ил тод байгууллага байхад оршино.

- Гүн хүндлэл;
- Урам зориг;
- Цог Золбоо;
- Бүтээлч сэтгэлгээ;
- Хөрвөх чадвар;
- Эерэг хандлага

ОЮУНЫГ ТЭТГЭЖ, ЖАРГАЛ БЭЛЭГЛЭНЭ

ОНЫ ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

Монгол ТВ нь 2022 ондоо Нийт 512978 минут буюу 8550 цагийн шууд болон серверийн шинэ, шинэлэг нэвтрүүлэг, контентуудыг бэлтгэн хүргэсэн.

Үүнээс:

- Кино гадаад нэвтрүүлгийн продакшн 163111 минут буюу нийт эфирийн 46 хувийг
- Ярилцлага болон шууд нэвтрүүлгийн продакшны Өнөө өглөө хөтөлбөр 73378 минут буюу нийт эфирийн 20.8 хувийг
- Нэвтрүүлгийн продакшны бэлтгэн хүргэдэг шоу нэвтрүүлгүүд 63597 минут буюу нийт эфирийн 18.2 хувийг
- Мэдээ болон нийгмийн нэвтрүүлгийн продакшн 52403 минут буюу нийт эфирийн 15 хувийг тус тус нийлүүлсэн.

Нэвтрүүлгүүдээс дурьдвал:

- Voice of Mongolia дэлхийн хэмжээний шоу нэвтрүүлгийн 3-р улирлыг амжилттай хийж гүйцэтгэсэн.
- Үндэсний их баяр наадмыг 13 дахь жилдээ шууд дамжуулан хүргэжээ.
- One championship холбооны албан ёсны онцгой эрхтэйгээр "Road to one Mongolia" шоуг Монголдоо анх удаа хийсэн.Сүлжээний шинэ нэвтрүүлэг болох "Love menu"-ийн эхний улирлыг амжилттай хийж гүйцэтгэжээ.

Мөн үзэгчдийн дунд үргэлж хүлээлт үүсгэдэг Чимгээ шоу, Чимээгүй номын сан, Ардын буйдан зэрэг нэвтрүүлгүүдээ үзэгч түмэндээ хүргэсээр байна. Мөн бизнесийн номер нэг шоу болох "Apprentice Mongolia" шоу нэвтрүүлгийн 2 дахь улирлыг амжилттай эхлүүлээд байна.

46%
Кино гадаад нэвтрүүлгийн продакшн

20.8%
Ярилцлага болон шууд нэвтрүүлгийн продакшн


18.2%
Нэвтрүүлгийн продакшны шоу нэвтрүүлгүүд

15%
Мэдээ болон нийгмийн нэвтрүүлгийн продакшн

	2021	2022	Жилийн өөрчлөлт
Нийт компани			
Нийт ажиллагсад	144	142	-2
Хувьцаа эзэмшигч	1	2	1
Нийт харилцагч байгууллагууд	142	173	31
Нийт зохион байгуулсан эвэнт	3	2	-1
Нийт бүтээсэн шоу	14	11	-3
Бүрэн хэмжээний кино	1	0	-1
Нийт бүтээсэн реклам	3	1	-2


ТЕЛЕВИЗИЙН САЛБАР

НИЙТ ҮЗЭГЧДИЙН ТОО



1.9 САЯ ҮЗЭГЧ ҮНДЭСНИЙ ХЭМЖЭЭНД


ҮЗЭГЧДИЙН ТЕЛЕВИЗ ҮЗДЭГ ЦАГ МЯН.ХҮН



ТВ РЕЙТИНГ 2021

МОНГОЛ TV Монгол телевиз #5

ТЕЛЕВИЗ ҮЗЭХЭД ЗАРЦУУЛДАГ ЦАГ ХУГАЦАА



Иргэд ажлын өдрүүдэд дунджаар 103 минут, амралтын өдрөөр 211 минутыг тв үзэхэд зарцуулдаг

Үзэх дуртай телевизийн нэвтрүүлэг

- The Voice of Mongolia #1
- Shark tank Mongolia #6
- Ардын буйдан #8
- Чимээгүй номын сан #22

МПЕРС ХХК



Үйл ажиллагааны чиглэл

Эд мөнгөний хонжворт сугалаа гаргах тусгай зөвшөөрдийн дагуу (лотто)

Товч танилцуулга

МПЕРС ХХК нь 2019 онд байгуулагдсан ба 2022 онд эд мөнгөний хонжворт сугалаа гаргах тусгай зөвшөөрөл аван 2022 оны 11 сараас үйл ажиллагаагаа эхлүүлсэн. Бидний зорилго Монголын хамгийн том лотто болох зорилгыг тээн одоогийн байдлаар Монгол ТВ болон Ард Санхүүгийн Нэгдэлийн Ард Апптай хамтран идэвхтэй үйл ажиллагаа явуулж байна.

Зорилго

Монгол улсад олон улсын стандартад нийцсэн лоттог нутагшуулах

Хүний тоо

2



ДЭЛХИЙН ЖИШИГТ НИЙЦСЭН, ОЛОН УЛСЫН
СТАНДАРТЫН ДАГУУ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛАХ 6/42
ЛОТТО.



2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

ОНЫ ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

- Бизнесийн үндсэн ажиллагаагаа өргөжүүлэх хүрээнд Сангийн яамнаас 2022 оны 11 сарын 7-ны өдөр “Эд мөнгөний хонжворт сугалаа явуулах” тусгай зөвшөөрлийг 3 жилийн хугацаатайгаар авсан.
- Тусгай зөвшөөрлийн дагуу Монголд анх удаа олон улсын жишигт нийцсэн, хамгийн хүртээмжтэй, хамгийн магадлал өндөртэй, 6/42 Лоттог Jackpot хэмжээ 300,000,000 төгрөгөөр эхлүүлэн олон нийтэд танилцуулав.
- 6/42 Лоттог Монголын хамгийн олон хэрэглэгчтэй Ард Аппын Үйлчилгээ цэсэнд оруулснаар 1 сая гаруй харилцагч төгрөгөөр болон АрдКойноор хөнгөлүүлж авах боломж нээгдэв.
- 6/42 Лотто нь долоо хоног бүрийн ням гарагт Өнөө Өглөө нэвтрүүлгийн оргил цаг болох 11:00 цагаас тохирлоо олон нийтэд нээлттэйгээр хүргэж эхлэв. Анхны тохирлыг 11 сарын 13 өдөр хүргэж, нийт 5,000 гаруй хүмүүс оролцов.




- Үйл ажиллагааг эхлүүлснээс хойш 7 тохирол явуулж 12 мянган харилцагчтай болж 70,000 гаруй тасалбар борлуулжээ
- Нийт 7 тохирлын хугацаанд 3,000 орчим харилцагчдад 74.5 сая төгрөгийн хонжворыг олгосон
- 6/42 Лоттоны Jackpot шагналын сан 300 сая төгрөгөөс эхлэж байсан бол 343 сая төгрөгт хүрэв





2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

АЗИД ТЭРГҮҮЛЭГЧ, ДЭЛХИЙД 29-Т
ЭРЭМБЭЛЭГДЭХ, ОЛОН УЛСЫН ISO TC 36 СТАНДАРТЫН
КИНО ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ЦОГЦОЛБОР



МОНГОЛ СОЁЛ УЛАМЖЛАЛАА СУРТАЛЧИЛАХ, КИНО УРЛАГИЙН
САЛБАРЫГ ДЭЛХИЙН ТҮВШИНД ГАРГАХ ТӨСӨЛ



ОРИ СТУДИОС ХХК



Үйл ажиллагааны чиглэл

Бүтээлч үйлдвэрлэл, кино контент, түрээс, эвент

Товч танилцуулга

Бид олон улсын стандартад нийцсэн техник, тоног төхөөрөмжийн тусламжтайгаар мэргэшсэн багтай хамтран дотоод, гадаадын кино, контентуудыг үндсэн форматын дагуу дуу, дүрсний өндөр чанартайгаар бүтээж, үзэгчдэд хүргэх, Монгол соёл, түүх, зан заншлаа дэлхийд сурталчлан таниулах, уран бүтээл туурвиж, үндэсний дархлааг тогтоох зорилготой.

Хүний тоо

10+

Ори Студиос төсөл нь эх хэл, түүх, өв соёлоо дээдэлсэн эх оронч үзэлтэй Монгол хүнийг хөгжүүлэх, нийгмийг соён гэгээрүүлэх түүнчлэн үндэсний хэв шинж, үзэл бодол, гүн ухаан, гоо зүй, соёл, амьдралын хэв маягийг харуулсан ОУСтандартад нийцсэн бүтээл туурвих зорилготой кино болон контент үйлдвэрлэгчдийн нэгдсэн медиа хабыг байгуулж, ирээдүй хойч үедээ оюуны өвийг үлдээнэ.

Алсын хараа

Чанартай уран бүтээлээс соён гэгээрэл, мэдлэг, соёлын дархлаа, үнэт зүйлсийг бий болгон бүтээлч соёлыг цогцлооно.

Үнэт зүйлс

- Чанартай бүтээл;
- Чин сэтгэл;
- Ёс зүй;
- Хамтын зүтгэл;
- Үзэгч;
- Оюуны өмч;
- Нийгмийн хариуцлага;
- Төгөлдөршил

ТА ӨӨРИЙН САНААГАА БҮТЭЭЛ БОЛГО
ОРИ СТУДИОС ЭНЭ БҮГДИЙГ БОЛОМЖТОЙ БОЛГОНО



ORI STUDIOS

ОУ-ЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА

Энэхүү ажлын хүрээнд бид Унгарын томоохон кино студиудтэй холбогдон Ориго, Корда, Астра, Vision Team, Movie Set, Фокс-нд зочилж, туршлага солилцсон.

Эдгээр студиудийн төлөөллийг Монголд хүлээн авч, өөрсдийн төслийг танилцуулан зөвлөх үйлчилгээний хүрээнд хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллаж байна.



ЭВЕНТ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ



"ARTSCAPE" МОНГОЛЫН ХАМГИЙН АНХНЫ МЕДИА АРТ БОЛОН УРАН ЗУРАГ ХОСОЛСОН ҮЗЭСГЭЛЭН

1сая140К социал хандалтыг 7 хоногт
11/30 зураг амжилттай борлуулсан

ОУ-ЫН ПРОДЮСЕРУУД ХҮЛЭЭН АВАХ АРГА ХЭМЖЭЭ

7 продюсер
50 VIP зочид
90mins хөтөлбөр
Хамтарч ажиллах хэлэлцээр




ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ФОРУМУУД



ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ ҮНДЭСТЭН

Хөрөнгө оруулагч үндэстэн форумд оролцон бонд болон төслөө танилцуулав.

33 хөрөнгө оруулагч 1 тэрбум төгрөгийг бонд-д хөрөнгө оруулсан байна.



ХӨРӨНГӨТӨН

Хөрөнгөтөн форумд оролцон бонд болон төслөө танилцуулав.

СУДАЛГАА

Студийн үйл ажиллагаатай холбоотой судалгаа

- Mini theater equipment research for preproduction
- Галын наадмын үйлчилгээ үзүүлэх судалгаа
- KESOP
- Натурын зураг авалт

Санхүүжилттэй холбоотой судалгаа

- Унгарын экспорт импортын банк
- Ногоон зээл
- Азийн хөгжлийн банк
- EBRD Star Venture program

Студитэй холбоотой судалгаа

- Үзвэр үйлчилгээтэй холбоотой суурь мэдээллүүд
- LA shows
- ОУ-ын кино студиудийн судалгаа
- Мастер класс төсөл



**ЭЗЭМШИХ
ИРЭЭДҮЙ**

БҮТЭЭХ УХАМСАР

MSE: TNGR



ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

ТЭНГЭРЛИГ МЕДИА ГРУПП ХК-ийн хувьцаа эзэмшигчдэд

Дүгнэлт

Бид Тэнгэрлиг Медиа Групп ХК (цаашид "компани" гэх)-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр тасалбар болгосон орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон бусад тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бид, компанийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, уг өдрөөр тасалбар болгосон орлогын дэлгэрэнгүй тайлан, мөнгөн гүйлгээг бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (цаашид "СТОУС" гэх)-ын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлсэн байна гэж дүгнэж байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандарт (цаашид "АОУС" гэх)-ын дагуу гүйцэтгэсэн болно. Уг стандартын дагуу бидний хүлээх үүргийг энэхүү тайлангийн Санхүүгийн Тайлангийн Аудиттай холбоотой Аудиторын Үүрэг хэсэгт тусгасан. Бид Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Олон Улсын Стандартын Зөвлөлөөс баталсан Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм (цаашид "МНБЕЗ-н дүрэм" гэх)-ийн дагуу компаниас хараат бус ба МНБЕЗ-н дүрмийн бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын нотолгоо нь аудитын дүгнэлт гаргах хангалттай бөгөөд зохистой үндэслэл болно гэж итгэж байна.

Санхүүгийн тайлантай холбоотой Удирдлага болон Засаглах Эрх Бүхий Этгээдийн Үүрэг

Удирдлага нь санхүүгийн тайлангаа СТОУС-ын дагуу бэлтгэн, шударгаар илэрхийлэх, эдгээр санхүүгийн тайланг алдаа эсвэл санаатай зальт үйлдлээс үүсэлтэй материаллаг хэмжээний алдаагүйгээр бэлтгэж, шударгаар илэрхийлэхийн тулд удирдлагаас шаардлагатай гэж тогтоосон дотоод хяналтыг хэрэгжүүлэх үүрэгтэй.

Санхүүгийн тайланг бэлтгэхдээ компанийн татан буулгах, үйл ажиллагааг нь зогсоох, эсвэл үүнээс өөр боломжит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд Удирдлага компанийн үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах чадамжийг үнэлэх, тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг ашиглан санхүүгийн тайлангаа бэлтгэх үүрэгтэй.

Засаглах эрх бүхий этгээд нь компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэгтэй.

Санхүүгийн Тайлангийн Аудиттай холбоотой Аудиторын Үүрэг

Санхүүгийн тайлан нь бүхэлдээ алдаа эсвэл санаатай зальт үйлдлийн улмаас материаллаг хэмжээний алдаагүй илэрхийлэгдсэн эсэх талаар ул үндэслэлтэй нотолгоо олж авах болон бидний дүгнэлтийг агуулсан аудитын тайлан гаргах нь бидний зорилго юм. Ул үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудит нь байнга

► "Хүлээгдхүүнүү аудит" ХХК
Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 6-р хороо,
Бага тойруу /14201/, Самбуугийн гудамж 6-р барилга 4 давхар, 402 тоот
Утас/Факс: +(976)-7014 0505

ХҮЛЭГ Г. ХҮНИЙ
АУДИТ ХХК 5

материаллаг хэмжээний алдааг илрүүлдэг гэсэн баталгаа болохгүй. Алдаатай илэрхийлэл нь алдаа эсвэл санаатай зальт үйлдлээс үүсч болох ба дангаараа эсвэл нийтдээ эдгээр санхүүгийн тайланд үндэслэн шийдвэр гаргах санхүүгийн тайлангийн хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллаг гэж үздэг.

АОУС-ын дагуу хийсэн аудитын нэг хэсэг байдлаар бид мэргэжлийн шийдэл гарган, аудитын туршид мэргэжлийн үл итгэх үзлийг баримтлан ажилладаг. Үүнээс гадна:

- Заль мэх эсвэл алдааны улмаас санхүүгийн тайлан материаллаг алдаатай илэрхийлэгдэх эрсдлийг тодорхойлж, түүнийг үнэлэн уг эрсдэлд тохирох аудитын горимыг боловсруулан хэрэгжүүлж, өөрсдийн санал дүгнэлтийн үндэслэл болохуйц хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоог олж авдаг. Заль мэхнээс үүссэн материаллаг алдааг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүссэн материаллаг алдааг илрүүлэхгүй байх эрсдэлээс харьцангуй их байдаг. Учир нь заль мэхэнд хуйвалдаан, баримт бичгийг хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу тайлагнах, дотоод хяналтыг үл ойшоох явдлууд орсон байж болно.
- Компанийн дотоод хяналтын үр ашигт байдлын талаар санал дүгнэлт гаргах зорилгоор биш харин тухайн нөхцөл байдалд тохирох аудитын горимыг боловсруулах зорилгоор аудитад хамаарах дотоод хяналтын талаар ойлголт олж авдаг.
- Удирдлагын ашигласан нягтлан бодох бүртгэлийн бодлогын тохиромжтой байдал, хийсэн нягтлан бодох бүртгэлийн тооцоолол болон холбогдох тодруулгын ул үндэслэлтэй байдлыг үнэлдэг.
- Мөн олж авсан аудитын нотолгоон дээр үндэслэн компанийн тасралтгүйгээр үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх чадамжид мэдэгдхүйц эргэлзээ төрүүлэхүйц үйл явдал, нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал байгаа эсэхийг тодорхойлж, нягтлан бодох бүртгэлийн өөдрөг төсөөллийн суурийг удирдлага зохистойгоор хэрэглэсэн эсэхийг дүгнэдэг. Хэрэв бид материаллаг хэмжээний тодорхой бус байдал оршин байна гэж үзвэл аудитын тайландаа түүнтэй холбоотой санхүүгийн тайлангийн тодруулгад анхаарал хандуулах эсвэл хийсэн тодруулга нь хангалтгүй байна гэж үзвэл аудитын санал дүгнэлтээ өөрчилдөг. Бидний дүгнэлт нь аудитын тайлан гаргах өдөр хүртэлх олж авсан аудитын нотолгоонд суурилдаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал эсвэл нөхцөлүүд нь компанийг өөдрөг төсөөллөө үргэлжлүүлэхээ зогсооход хүргэх нөлөө үзүүлж болно.
- Тодруулгыг багтаагаад санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулга, бүтэц, агуулга ба санхүүгийн тайлангууд нь үнэн зөв толилуулгын шаардлагыг хангахуйц хэмжээнд гол гол ажил гүйлгээ ба үйл явдлыг илэрхийлсэн эсэхийг үнэлдэг.

Бид аудитын төлөвлөсөн цар хүрээ ба хугацаа, аудитынхаа явцад олж илрүүлсэн дотоод хяналт дахь томоохон эерчил, дутагдлыг оруулаад нөлөө бүхий аудитын илрүүлэлтүүд, бусад асуудлуудаар засаглах эрх бүхий удирдлагатай харилцдаг.

Гарын үсэг зурсан:


И.Гүрриг-ээ
Гүйцэтгэх захирал
Хүлээгдхүүнүү Аудит ХХК

2023 оны 03 дугаар сарын 27-ны өдөр
Монгол Улс, Улаанбаатар хот

► "Хүлээгдхүүнүү аудит" ХХК
Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 6-р хороо,
Бага тойруу /14201/, Самбуугийн гудамж 6-р барилга 4 давхар, 402 тоот
Утас/Факс: +(976)-7014 0505

ХҮЛЭГ Г. ХҮНИЙ
АУДИТ ХХК 6

ТЭНГЭРЛИГ МЕДИА ГРУПП САНХҮҮГИЙН ТАЙЛАН 2022

ТУСДАА САНХҮҮ БАЙДЛЫН ТАЙЛАН сая.төг

АУДИТЛАГДСАН

Санхүүгийн тайлан / мян.төг	2021	2022	YoY	YoY %
Мөнгөн хөрөнгө	1,221	5	(1,216)	-99.6%
Дансны авлага, Бусад авлага, Татвар НДШ авлага	1,377	1,187	(190)	-13.8%
Урьдчилж төлсөн зардал	47	-	(47)	-100%
Урт хугацаат ХО	13,831	13,433	(398)	-2.9%
Үндсэн хөрөнгө	2	5	3	150%
Бусад эргэлтийн бус хөрөнгө	13,285	3,704	(9,581)	-72.1%
Нийт хөрөнгийн дүн	29,763	18,334	(11,429)	-38.4%
Дансны өглөг, хүүний өлөг	117	193	77	64.9%
Цалингийн өглөг	-	11	11	100%
Татвар, Хойшлогдсон татвар, НДШ өглөг	1,381	294	(1,087)	-78.7%
Урт, богино хугацаат зээл	1,430	1,615	185	13%
Бусад богино, урт хугацаат өр	2,302	2,737	435	18.9%
Эзний өмч	24,533	13,484	(11,049)	45%
Өр ба эзний өмчийн дүн	29,763	18,334	(11,429)	-38.4%

ТУСДАА ОРЛОГЫН ТАЙЛАН сая.төг

АУДИТЛАГДСАН

Орлогын тайлан / сая төг	2021	2022	YoY	YoY %
Үйл ажиллагааны орлого	-	44	44	100%
Бусад орлого	927	-	(927)	-100%
Нийт зардал	1,180	903	(277)	-23.5%
Ерөнхий удирдлагын зардал	1,099	561	(538)	-48.9%
Борлуулалт, маркетингийн зардал	7	27	20	285%
Санхүүгийн зардал	66	315	249	377%
Бусад зардал	8	-	(8)	-100%
Гадаад валютын ханшийн зөрүүний олз	713	125	(588)	82.5%
ТАТВАРЫН ӨМНӨХ АШИГ	460	(734)	(1,194)	-259%
Татвар	46	-	(46)	-100%
АШИГ / АЛДАГДАЛ	414	(734)	(1,148)	-277%


ТУСДАА МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН сая.төг

АУДИТЛАГДСАН


Мөнгөн гүйлгээний тайлан / сая төг	2021	2022	YoY	YoY %
Үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	(236)	(300)	(64)	27%
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	179	(1,099)	(1,278)	-713%
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	1,276	183	(1,093)	-85.6%
Зээлээс хүлээн авсан мөнгө	1,464	185	(1,279)	-87.3%
Зээл урьдчилгаанд төлсөн мөнгө	187	(2)	(189)	-101%
Төрөл бүрийн хандив	1	-	(1)	-100%
Цэвэр мөнгөн гүйлгээ	1,219	(1,216)	(2,435)	-199.7%
Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл	2	1,221	1,219	60,950%
Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,221	5	(1,216)	-99.6%

САНХҮҮГИЙН ГОЛ ҮЗҮҮЛЭЛТҮҮД сая.төг


ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭ сая.төг




НИЙТ ХӨРӨНГӨ сая.төг




НИЙТ ЭЗДИЙН ӨМЧ сая.төг




НИЙТ ӨР ТӨЛБӨР сая.төг



БУСАД ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГО сая.төг



ХУВЬЦААНЫ ХАНШ мян.төг



Үзүүлэлт	2021	2022	Жилийн өөрчлөлт
Нийт компани	5	6	1
Хувьцаа эзэмшигч	556	1,005	449
Хувьцааны ханш	20,000₮	16,900₮	(3,100)
Нийт арилжигдсан хувьцаа	1,211,829ш	39,524ш	(1,172,305)ш

MSE: TNGR

www.tngr.media

2022 OH